

Жижиг аж ахуйн нэгжийн уур амьсгалын тодруулга, тайлагналын зарим асуудал

Climate-related Disclosures in Small Enterprises: Issues and Reporting Practices

Э. Вандандулам¹

Хураангуй

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн ихэнхийг бүрдүүлдэг жижиг, дунд бизнесүүд нь үйлдвэрлэлийн бохирдлын гол эх үүсвэрийн нэг болж байгааг олон улсын судалгаанууд харуулж байна. Ногоон эдийн засаг, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал дэлхий нийтийн хэмжээнд эрчимжиж буй энэ үед ЖДҮ-үүд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалтай холбоотой мэдээллээ ил тод тайлагнах шаардлагатай болж байна. Энэхүү судалгаагаар аудитын үйлчилгээ эрхэлдэг жижиг байгууллагын жишээн дээр СТОУС S1, S2 болон SASB-ийн стандартуудад тулгуурлан уур амьсгалтай холбоотой тодруулгыг боловсруулж, жижиг аж ахуйн нэгжүүдийн тогтвортой байдлын мэдээллийг олон улсын түвшинд нийцүүлэн тайлагнах боломжийг судалсан болно.

Түлхүүр үгс: уур амьсгалтай холбоотой эрсдэл, уур амьсгалын боломж, хүлэмжийн хий, хүлэмжийн хийн шууд болон шууд бус ялгаруулалт

Abstract

Small and medium-sized enterprises (SMEs), which constitute the majority of active businesses in Mongolia, are identified as major contributors to industrial pollution worldwide. As the global focus on green economy and sustainable development intensifies, SMEs are increasingly expected to reduce greenhouse gas (GHG) emissions and disclose climate-related information transparently. This study examines the practical application of international sustainability standards – IFRS S1, IFRS S2, and the SASB standard for professional services – through a case study of a small audit firm. The findings highlight the feasibility of aligning SME sustainability reporting with global frameworks.

Keywords: climate-related risks, climate opportunities, greenhouse gas, direct and indirect GHG emissions

¹ "Эрдэнэт цогцолбор" дээд сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: vandandulam@erdenetis.edu.mn

Удиртгал

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээрээ ногоон эдийн засагт шилжих, тогтвортой хөгжлийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлж байгаа нь бизнесийн бүх салбар, ялангуяа жижиг, дунд аж ахуйн нэгжүүд (ЖДҮ)-ийн оролцоо, хариуцлагыг онцлон авч үзэхэд хүргэж байна. Монгол Улсад бүртгэлтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн 77 хувийг ЖДҮ эзэлдэг бөгөөд эдгээр нь ажиллах хүчний 70 гаруй хувийг шингээж, эдийн засагт чухал байр суурь эзэлдэг ч нөгөөтэйгүүр, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллөөрөө үлэмж хувь нэмэр оруулж байна. Дэлхийн жишгээр авч үзвэл, нийт үйлдвэрлэлийн бохирдлын 60 гаруй хувийг жижиг, дунд бизнесүүд үүсгэдэг гэсэн судалгаа бий.

Олон улсын түвшинд байгууллагууд тогтвортой байдлын мэдээллээ ил тод болгож, хүлэмжийн хийн (ХХ) ялгарлыг хэмжих, бууруулах бодлого хэрэгжүүлснээр хэрэглэгч, хөрөнгө оруулагчдад хариуцлагатай бизнес эрхлэгч гэдгээ батлан харуулах, гадаадын зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх боломж бүрдэж байна. Монгол Улсад энэхүү чиглэл харьцангуй шинэ тул ЖДҮ-үүдийн уур амьсгалтай холбоотой мэдээлэл тайлагналын өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй арга зүйг тодорхойлон, олон улсын стандартад нийцсэн уур амьсгалын тодруулга боловсруулах боломж, ач холбогдлыг судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Энэхүү судалгаагаар уур амьсгалын эрсдэл, боломжийг ЖДҮ-ийн түвшинд хэрхэн тодорхойлж, тайлагнаж байгааг үнэлэхийн зэрэгцээ СТОУС S1, S2 стандарт болон Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын

(SASB) хүрээнд жишээ байгууллагын уур амьсгалын тодруулгыг бэлтгэх замаар стандартад суурилсан мэдээллийн агуулга, хэрэгцээ шаардлагыг тодорхойлохыг зорьсон. Судалгаанд Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч, тэдгээрийн санхүүгийн тайлангийн тодруулга, үйл ажиллагааны мэдээлэл, уур амьсгалтай холбоотой ойлголт, дадал хэвшлийн талаарх асуулгын судалгаа авсан бөгөөд тухайн мэдээлэлд үндэслэн уур амьсгалын мэдээллийн хандлагыг тоон ба чанарын аргаар шинжилсэн болно. Мөн тус бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг аудитын үйлчилгээний нэгэн компанийн жишээн дээр уур амьсгалын тайлагнал бэлтгэн, мэдээллийн ач холбогдол, хэрэгжилтийн боломжийг нарийвчлан судалсан нь энэхүү өгүүллийн гол онцлог юм.

Судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг 24 жижиг, дунд аж ахуйн нэгжийн уур амьсгалтай холбоотой тодруулгын хэрэгжилтийн байдал тун доогуур байгаа нь судалгааны эхний үр дүнгээс тодорхой харагдаж байна. Хүснэгт 1-ээс үзэхэд эдгээр байгууллагын 92 хувь нь уур амьсгалын эрсдэл, боломжийг тодорхойлох, үнэлэх, хяналт тавих бодлого, бүтэц бүрдээгүй байна. Судалгаанд хамрагдсан байгууллагуудаас зөвхөн хоёр нь (20-30 ажилтантай ангилалд) уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хохирлыг бууруулах хөрөнгө төсөвлөсөн гэж хариулсан бол бусад нь ямар ч төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байгааг харуулж байна.

Дээрх үр дүнг гүнзгийрүүлж, уур амьсгалтай холбоотой хэмжилт, нөлөөллийн талаар байгууллагууд хэрхэн ажиллаж байгааг

**Хүснэгт 1. Уур амьсгалын эрсдэл, боломжийн талаар баримталж
байгаа засаглалын бодлого**

Үзүүлэлт	Танай байгууллагад доорх асуудлууд албан болон албан бусаар хэрэгжиж байна уу?			
	Уур амьсгалын эрсдэл, боломжийн нөлөөллийг тодорхойлох бодлоготой	Уур амьсгалын эрсдэл, боломжийн нөлөөллийг тооцож тайлагнах ажилтантай	Уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хохирлыг бууруулахад хөрөнгө төсөвлөсөн
0-10 ажилтантай	0	0	0	0
11-20 ажилтантай	0	0	0	0
21-30 ажилтантай	0	0	2	2
Нийт	0	0	2	2

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүснэгт 2. Уур амьсгалын эрсдэл, боломжийн хэмжилтийн хэрэгжилт

Үзүүлэлт	Танай байгууллагад доорх асуудлууд албан болон албан бусаар хэрэгжиж байна уу?				
	Уур амьсгалтай холбоотой эрсдэл боломжийг тодорхойлсон	Манай байгууллага хүлэмжийн хийн шууд ялгарлыг хэмждэг (Хамрах хүрээ 1)	Манай байгууллага хүлэмжийн хийн шууд бус ялгарлыг хэмждэг (Хамрах хүрээ 2)	Байгаль орчинд эерэг нөлөөтэй, ногоон ажлын байр бий болгосон	Байгаль орчинд эерэг нөлөөтэй ажлыг тогтмол бус хийдэг
0-10 ажилтантай	0	0	0	0	1
11-20 ажилтантай	0	0	0	0	4
21-30 ажилтантай	0	0	0	0	7
Нийт	0	0	0	0	12

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүснэгт 2 харуулж байна. Судалгаанд хамрагдсан байгууллагуудын аль нь ч хүлэмжийн хийн шууд болон шууд бус ялгарлыг тооцоолох, хэмжих системгүй байсан бөгөөд байгаль орчинд эерэг нөлөөтэй тогтвортой үйл ажиллагааг тогтмол хийдэг гэж өөрийгөө тодорхойлсон хувь 50% байсан ч энэ нь ихэвчлэн нэг удаагийн цэвэрлэгээ, мод тарих зэрэг улирлын чанартай арга хэмжээгээр хязгаарлагдаж байна.

Жижиг бизнесүүдэд тогтвортой байдлын стандартын хэрэгжилтийг турших зорилгоор нэг байгууллагыг жишээ болгон

сонгож, кейс шинжилгээ хийсэн. Сонгосон “А аудит” ХХК нь өмнө нь уур амьсгалын тайлан бэлтгэж байгаагүй ч СТОУС S2 стандартын дагуу 2023 оны мэдээлэлд үндэслэн хүлэмжийн хийн ялгарлаа анх удаа тооцсон. Тус компани нь автомашины хэрэглээнээс (Хамрах хүрээ 1) 2.64 tCO₂e, цахилгааны хэрэглээнээс (Хамрах хүрээ 2) 3.82 tCO₂e, үйл ажиллагааны сүлжээнээс (Хамрах хүрээ 3) 8.0 tCO₂e ялгаруулсан нь нийт 14.46 tCO₂e болж байна. Энэ тооцооллыг хийснээр тус байгууллага 2024 онд хүлэмжийн хийн ялгарлыг 5 хувиар бууруулах зорилт тавьж, эрчим

хүчний хэрэглээг хязгаарлах, ногоон бүтээн байгуулалтыг дэмжих бодлого хэрэгжүүлэхээр тусгасан.

Жишээ компани нь тогтвортой байдлын талаарх албан ёсны бодлого, стратеги, хяналттай бүтэцтэй байгаагүй хэдий ч ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаанд байгальд ээлтэй дадал хэвшил нэвтэрч эхэлсэн нь эерэг чиг хандлагын илрэл юм. Жишээлбэл, нэг удаагийн аяга хэрэглэхээс татгалзах, цаасны хэрэглээг бууруулах, дахин цэнэглэдэг батерей ашиглах зэрэг нь шууд бус байдлаар ч уур амьсгалд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад хувь нэмэр оруулж байна.

Судалгааны үр дүнг олон улсын судалгаатай харьцуулбал, төстэй байдал ажиглагдана. Тухайлбал, Miklosik & Evans (2021)-ийн судалгаагаар Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн компаниуд тогтвортой байдлын тайланд байгаль орчны түлхүүр үгсийг хэрхэн тусгаж байгааг Хүснэгт 3-т харууллаа. Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 99.5% нь хүлэмжийн хийн ялгарлын талаарх мэдээлэл оруулсан байдаг нь уур амьсгалын мэдээллийн ач холбогдол их байгааг харуулж байна. Гэтэл Монголын жижиг аж ахуйн нэгжүүдэд ийм ойлголт, шаардлага хангалтгүй түвшинд байгааг бидний судалгаа нотолж байна.

Монголын байгууллагуудад хэрэгжүүлэх

голшаардлага нь уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжийг зөв тодорхойлох, үүнийг бодлого, стратегитэй уялдуулах, мөн хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах арга зүйг эзэмших явдал юм. Үүнийг олон улсын практикт тохируулан хэрэгжүүлэх боломжийг СТОУС S1, S2 стандартууд тодорхой зааж өгдөг. Хүснэгт 4-т эдгээр стандартын хүрээнд тайлагнах ёстой үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг харуулсан бөгөөд судалгаанд эдгээр үзүүлэлтүүдийг хэрэглэх замаар жижиг байгууллагын мэдээллийг стандартчилж боловсруулах боломжийг туршсан.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, судалгааны үр дүнгээс харахад уур амьсгалын тайлагнал нь зөвхөн томоохон корпорацид хамааралтай асуудал биш бөгөөд жижиг аж ахуйн нэгжүүд ч мөн адил уур амьсгалд үзүүлж буй нөлөөллөө хянаж, бууруулах үүрэгтэй гэдгийг баталж байна. Судалгаанд ашигласан олон улсын стандарт, арга зүй нь жижиг бизнесүүдэд практикт хэрэгжүүлж болохуйц, үр дүнтэй хандлага болохыг кейс судалгаа нотолж өглөө.

Дүгнэлт

Монгол Улсад жижиг, дунд аж ахуйн нэгжүүд эдийн засгийн болон нийгмийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байгаа хэдий ч уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны тогтвортой байдлын талаарх ойлголт, бодит арга хэмжээний хэрэгжилт

Хүснэгт 3. Түлхүүр үг бүрээр цуглуулсан мэдээллийн тойм

Түлхүүр үг	Тайланд дурдсан тоо	Холбогдох хамаарал	Сэдвийн хувьд дундаж хамаарал
Байгаль орчны нөлөө	3,142	2,636	83.9%
Уур амьсгалын өөрчлөлт	588	561	95.4%
Хүлэмжийн хийн ялгарал	604	601	99.5%
Уул уурхайн ашиглалтын ул мөр	106	46	43.4%
Нийт	4,400	3,844	86.6%

Эх сурвалж: Miklosik & Evans (2021)

Хүснэгт 4. Зөвлөмж болгож буй тодруулга

Засаглал	Стратеги	Эрсдэлийн удирдлага	Хэмжилт ба зорилтууд
Уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудын талаар байгууллагын бодлого, засаглалыг ил тод болгох	Байгууллагын бизнес, стратеги, санхүүгийн төлөвлөлтөд уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудын бодит болон болзошгүй нөлөөллийг ил тод болгох	Байгууллага уур амьсгалтай холбоотой эрсдэлийг хэрхэн тодорхойлж, үнэлж, удирддаг талаар тодруулах	Уур амьсгалтай холбоотой холбогдох эрсдэл, боломжуудыг үнэлэх, удирдахад ашигласан хэмжүүр, зорилтуудыг ил тод мэдээлэх
Санал болгож буй тодруулга	Санал болгож буй тодруулга	Санал болгож буй тодруулга	Санал болгож буй тодруулга
а) Уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудын талаар удирдах зөвлөлийн хяналтыг тайлбарлах	а) Байгууллагын богино, дунд, урт хугацаанд тодорхойлсон уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудыг тайлбарлах	а) Уур амьсгалтай холбоотой эрсдэлийг тодорхойлох, үнэлэх байгууллагын үйл явцыг тайлбарлах	а) Байгууллагын стратеги болон эрсдэлийн удирдлагын үйл явцтай уялдуулан уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудыг үнэлэхэд ашигладаг хэмжүүрүүдийг тодруулах
б) Уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудыг үнэлэх, удирдахад удирдлагын гүйцэтгэх үүргийг тайлбарлах	б) Байгууллагын бизнес, стратеги, санхүүгийн төлөвлөлтөд уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудын нөлөөг тайлбарлах	б) Уур амьсгалтай холбоотой эрсдэлийг удирдах байгууллагын үйл явцыг тайлбарлах	б) Хамрах хүрээ 1, Хамрах хүрээ 2, шаардлагатай бол 3-р хамрах хүрээний хүлэмжийн хийн ялгаруулалт болон холбогдох эрсдэлийг тодруулах
		в) Уур амьсгалтай холбоотой эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах үйл явц нь байгууллагын ерөнхий эрсдэлийн удирдлагад хэрхэн нэгтгэгдэж байгааг тайлбарлах	в) Байгууллагын уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудыг удирдахад ашиглаж буй зорилтууд болон зорилтуудын эсрэг гүйцэтгэлийг тайлбарлах

Эх сурвалж: Financial Stability Board, 2017

хангалтгүй түвшинд байгааг судалгааны үр дүн харууллаа. Судалгаанд хамрагдсан 24 байгууллагын дийлэнх нь уур амьсгалын эрсдэл, боломжийг тодорхойлоогүй, хүлэмжийн хийн ялгарлыг хэмждэггүй бөгөөд байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийнхөө талаар албан ёсны бодлого, тайлангүй байгаа нь энэ чиглэлд мэдлэг, дэмжлэг, арга зүйн хомс байгааг илэрхийлж байна.

Кейс судалгаанд хамрагдсан “А аудит” ХХК-ийн жишээн дээр үндэслэн олон улсын СТОУС S1, S2 стандартын дагуу уур амьсгалтай холбоотой тодруулга бэлтгэх арга зүйг туршин хэрэглэсэн нь жижиг аж ахуйн нэгж ч олон улсын тогтвортой байдлын мэдээллийн шаардлагыг хангасан

байдлаар тайлагнал хийх боломжтойг харуулж байна. Энэхүү туршлага нь уур амьсгалын мэдээлэл бэлтгэх эхний алхмыг хийхэд заавал нарийн мэргэшсэн мэргэжилтэн шаардлагагүй, харин цахим платформ, ойлгомжтой арга зүй, байгууллагын дотоод идэвхи санаачилга хангалттай нөхцөл болдгийг нотолсон.

Судалгааны үр дүнгээс дараах үндсэн санал, дүгнэлтийг гаргаж болно. Үүнд:

- Жижиг аж ахуйн нэгжүүд уур амьсгалын нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих талаар хангалттай ойлголтгүй байгаа тул төр, мэргэжлийн холбоодоос арга зүйн сургалт, мэдээллийн дэмжлэг шаардлагатай байна.
- Уур амьсгалын тодруулгыг зөвхөн

- байгаль орчны шаардлага гэж хязгаарлалгүйгээр бизнесийн нэр хүнд, хөрөнгө оруулалт татах боломж, олон улсын зах зээлд өрсөлдөх давуу тал болгон ойлгох хандлагыг төлөвшүүлэх шаардлагатай.
- СТОУС S1, S2 стандартуудыг үндэслэн боловсруулсан арга зүйг кейс судалгаанд амжилттай хэрэгжүүлсэн нь жижиг байгууллагуудын хувьд тайлагналын жишиг хандлагыг бий болгох, суурь туршлага хуримтлуулах эхлэл болж байна.
 - Цаашид Монголын жижиг аж ахуйн нэгжүүд тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжих үүднээс уур амьсгалын мэдээлэл тайлагналын нэгдсэн арга зүй, зөвлөмжөөр хангагдаж, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.
- Эцэст нь, энэхүү судалгаа нь Монголын нөхцөлд уур амьсгалтай холбоотой мэдээлэл бэлтгэх практик боломжийг тодорхойлж, олон улсын стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх арга зүйн суурийг тавьсан анхны оролдлогын нэг болж байгаагаараа ач холбогдолтой юм.
- Цаашид Монголын жижиг аж ахуйн

Ашигласан материал

- Blundel, R., Monaghan, A., & Thomas, C. (2013). SMEs and Environmental Responsibility: A Policy Perspective. *Business Ethics: A European Review*, 22(3), 246-262. <https://doi.org/10.1111/beer.12020>
- EU Publications (2010). *SMEs and the Environment in the European Union*. <https://op.europa.eu/en/publication-detail/-/publication/aa507ab8-1a2a-4bf1-86de-5a60d14a3977>
- Fabian, O. & Emeka, O. (2022). Effect of Environmental Reporting on Liquidity of Firms in Nigeria. *Asian Journal of Advances in Research*, 15(2), 36-46.
- Financial Stability Board (2017). *Recommendations of the Task Force on Climate-related Financial Disclosures: Final report*. <https://assets.bbhub.io/company/sites/60/2021/10/FINAL-2017-TCFD-Report.pdf>
- ISSB (2023a). *IFRS S1 General Requirements for Disclosure of Sustainability-related Financial Information*. <https://www.ifrs.org/issued-standards/ifrs-sustainability-standards-navigator/ifrs-s1-general-requirements/#about>
- ISSB (2023b). *IFRS S2 Climate-related Disclosures*. <https://www.ifrs.org/issued-standards/ifrs-sustainability-standards-navigator/ifrs-s2-climate-related-disclosures>
- Marlowe, J. & Clarke, A. (2022). Carbon Accounting: A Systematic Literature Review and Directions for Future Research. *Green Finance*, 4(1), 71-87. <https://doi.org/10.3934/GF.2022004>
- Miklosik, A. & Evans, N. (2021). Environmental Sustainability Disclosures in Annual Reports of Mining Companies Listed on the Australian Stock Exchange (ASX). *Heliyon*, 7(7), e07505. <https://doi.org/10.1016/j.heliyon.2021.e07505>

PWC (2023). *IFRS Sustainability Disclosure Standards - Guidance, Insights and Where to Begin*. https://viewpoint.pwc.com/dt/gx/en/pwc/in_depths/in_depths_INT/in_depths_INT/ifrs-sustainability-disclosure-standards.html

SASB (2018). *Sustainability Accounting Standard: Professional & Commercial Services*. <https://carrotsandsticks.net/policies/323-35-professional-commercial-services-sasb-standards-2018>

World Resources Institute (2001). *The Greenhouse Gas Protocol: A Corporate Accounting and Reporting Standard*. <https://ghgprotocol.org/sites/default/files/standards/ghg-protocol-revised.pdf>

Орхон аймгийн Засаг даргын тамгын газар (2022). *Орхон аймгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өнөөгийн байдлыг тодорхойлох судалгаа*.

Санхүүгийн зохицуулах хороо (2020). *Судалгааны товхимол*. Улаанбаатар.

Санхүүгийн зохицуулах хороо (2022). *БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж*. Улаанбаатар.